4 ФИНТЕК ЗОХИЦУУЛАЛТЫН ИННОВАЦ ХАБ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГАА

Гүйцэтгэсэн: Б.Батчимэг[6]
Б.Тэргэл[7]
Б.Даваамаа[8]

[6] СЗХ, Сэндбоксын албаны дарга email: batchimeg_b@frc.mn
[7] СЗХ, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт email: tergel@frc.mn
[8] СЗХ, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн email: davaamaa@frc.mn

ХУРААНГУЙ

Сүүлийн жилүүдэд технологид суурилсан санхүүгийн үйлчилгээний зах зээл хурдтай хөгжин банк, санхүүгийн системд зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн олон төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ шинээр нэвтэрч байна. Технологийн энэхүү үр ашгийг ашиглахын сацуу санхүүгийн тогтвортой байдлаа хадгалах чиглэлд улс орнуудын зохицуулагч байгууллага, бодлого гаргагчид сэндбоксын зохицуулалт, инновацын хаб зэрэг төрөл бүрийн инновацын хурдасгуур хэрэгслийг ашиглаж байна. 2023 оны 2 дугаар улирлын байдлаар дэлхийн 90 орчим улс сэндбокс зохицуулалтыг нэвтрүүлээд байгаа бол 60 гаруй улс инновац хабыг санхүүгийн зохицуулагч байгууллагынхаа дэргэд байгуулсан статистик мэдээлэл байна. Манай улсын хувьд сэндбокс зохицуулалтын орчин 2021 онд нэвтрэн шинэ төрлийн технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг туршин амжилттай хэрэгжиж байна. Гэсэн хэдий ч дан ганц зохицуулалтын сэндбоксоос гадна санхүү, технологийн компаниудад бодлого, зохицуулалтын зөвлөгөө өгөх, тус салбарын мэргэжилтэн, боловсон хүчнийг чадавхжуулах, шинэ тутам хөгжиж буй финтек зах зээлийн талаарх судалгаа, шинжилгээг тогтмол гүйцэтгэх, санхүүгийн зохицуулагч байгууллагын хяналт, шалгалтын үйл ажиллагаанд технологийг нэвтрүүлэх зэрэг олон тооны ажлуудыг хийх хэрэгцээ, шаардлага үүсэж байна. Финтек зохицуулалтын инновац хаб нь эдгээр асуудлуудыг шийдэх, бүс нутагтаа тэргүүлэх, инновацад суурилсан ухаалаг санхүүгийн системийг хөгжүүлэхэд туслах инновац хурдасгуур, бодлогын нэгэн хувилбар байх боломжтой юм.

Түлхүүр үгс: *технологи, ухаалаг санхүүгийн систем, инновац хурдасгуур*

JEL ангилал: *E44, G28, O31, O38*

АГУУЛГА

I.	УДИРТГАЛ	104
II.	ФИНТЕКИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	105
	2.1. Финтекийн зах зээл	105
	2.2. Бодлого, зохицуулалтын орчин	107
III.	ФИНТЕКИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ ОЛОН УЛСАД	113
	3.1. Финтек салбарын зах зээл, хүлээгдэж буй ирээдүй	113
	3.2. Финтек салбарын зохицуулалт	115
	3.3. Инновацын хабын хөгжил олон улсад	117
IV.	ИННОВАЦЫН ХАБ БАЙГУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА	122
	4.1. Хэрэгцээ, шаардлага	122
	4.2. Давуу болон сул тал	125
	4.3. Эрсдэлийн менежмент	126
V.	ИННОВАЦЫН ХАБ	128
	5.1. Үндсэн зорилго, зорилт	128
	5.2. Үндсэн бүрэлдэхүүн	128
	5.3. Үйл ажиллагааны схем, зураглал	129
	5.4. Оролцогч талуудын шинжилгээ	130
	5.5. Засаглал, ажиллах зарчим	131
VI.	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	132
	ЭХ СУРВАЛЖ	135
	ХАВСРАЛТ I. ИННОВАЦЫН ХАБ БАЙГУУЛАХ БОДЛОГЫН САНАЛ /АНГЛИ ХЭЛ ДЭЭР/	136
	ХАВСРАЛТ II. ИННОВАЦЫН ХАБ БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН САНАЛ /АНГЛИ ХЭЛ ДЭЭР/	141

ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Монгол Улсын финтек зах зээлийн экосистем 105
Зураг 2. Банк бус санхүүгийн байгууллагын финтек зээлийн статистик 106
Зураг 3. Виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 107
Зураг 4. Сэндбоксын орчинд орохоор ирүүлсэн хүсэлт, үйлчилгээний төрлөөр 110
Зураг 5. Финтекийн салбарын жилийн орлого, өсөлтийн таамаглал 113
Зураг 6. Санхүүгийн салбарт тэргүүлэх бизнес салбаруудын орлого, өсөлтийн таамаглал 114
Зураг 7. Инновацын хаб болон сэндбоксын тархалт 118
Зураг 8. Англи Улсын инновацын хабын хөгжил 119
Зураг 9. Инновацын хабын бүрэлдэхүүн /санал/ 128
Зураг 10. Инновацын хаб байгуулахад оролцогч талуудын шинжилгээ 130
Зураг 11. Инновацын хабын бүтэц /санал/ 132

Хүснэгт 1. Санхүүгийн салбарын голлох хуулиуд, цахим үйлчилгээтэй холбоотой харилцааг тусгасан байдал 110
Хүснэгт 2. Цахим хөгжлийг дэмжих хуулиуд 111
Хүснэгт 3. Финтекийн зах зээлийн боломж ба сорилт 116
Хүснэгт 4. Үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө 133
Хүснэгт 5. Инновацын хаб үүсгэн байгуулах төсвийн санал 134

I. УДИРТГАЛ

Сүүлийн жилүүдэд санхүүгийн технологи буюу финтекийн хөгжил хурдсан уламжлалт банк, санхүүгийн салбарт урьд өмнө нь хүлээгдэж байгаагүй амар хялбар байдал, үр ашиг, хүртээмжийг авчирч байна. Гэсэн хэдий ч санхүүгийн салбарт өрнөж буй энэхүү хурдтай өөрчлөлтийг даган санхүүгийн зах зээлд шинэ төрлийн эрсдэлүүд үүсэх, санхүүгийн салбарын интеграцчлалыг хурдасган санхүүгийн систем, тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх зэрэг эрсдэлүүд ажиглагдаж байна. Иймд санхүүгийн зах зээлд шинээр үүсэж буй эрсдэлээс системийн тогтвортой байдал, хэрэглэгч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахын сацуу технологийн дэвшлийн зах зээлд авчирч буй үр шим, өгөөжийг боломжит түвшинд нь ашиглах чиглэлд улс орнуудын засгийн газар, бодлого гаргагчид, олон улсын байгууллагууд эрчимтэй ажиллаж байна.

Финтекийн энэхүү хөгжил Монгол Улсын зах зээлд ч мөн эрчимтэй нэвтэрч буй бөгөөд төрийн бодлого гаргагчид болон санхүүгийн зохицуулагч байгууллагууд технологийн дэвшлийг ашиглан санхүүгийн зах зээл, эдийн засгийн өсөлтийг дэмжин, тогтвортой хөгжилд хүрэх боломжийг эрэлхийлэн ажиллаж байна.

Санхүүгийн салбар дахь инновацыг нэмэгдүүлэх, түүний үр шимийг хүртэх олон боломж, хурдасгуур хэрэгслүүдийн нэг нь Финтекийн инновацын хаб юм. Финтекийн инновацын хаб нь санхүүгийн салбарын оролцогчид, гарааны бизнесүүд, технологийн компаниудын хөгжлийг дэмжих, хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэсэн санхүүгийн салбарын экосистемийг хамарсан төв бөгөөд санхүүгийн байгууллагууд, технологийн компаниуд, хөрөнгө оруулагчид, академик салбарынхан, болон төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны цэг болон финтек салбарын хөгжил, инновацыг дэмжих чиглэлд ажилладаг.

Энэхүү судалгаа нь Монгол Улсад финтекийн салбарыг дэмжсэн инновацын хаб байгуулахын ач холбогдлыг судлах, олон улсын сайн туршлагаас судлан өөрийн орны нөхцөл байдалд нийцсэн инновацын хабын үйл ажиллагааны гол зураглал, холбогдох тооцооллыг гаргах мөн цаашид уг төлөвлөгөөг ажил хэрэг болгоход шаардлагатай ерөнхий төлөвлөгөөг гаргахад чиглэсэн. Судалгааны дараах бүлгүүдэд Монгол Улсын финтек салбарын өнөөгийн нөхцөл байдал, олон улсын чиг хандлага, инновацын хабын олон улсын туршлага, Монгол Улсын санхүүгийн зах зээлд инновацын хаб байгуулах хэрэгцээ, шаардлагыг судлан, инновацын хабын үндсэн бүрэлдэхүүн, хэрэгжүүлэх үйл ажиллагааны зураглалыг эхний байдлаар боловсруулан, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг гарган тусгасан болно.

II. ФИНТЕКИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2.1. ФИНТЕКИЙН ЗАХ ЗЭЭЛ

Монгол Улсын санхүүгийн зах зээл нь банкны салбарт суурилсан бүтэцтэй бөгөөд саяхныг хүртэл манай улсын санхүүгийн салбарын 90 гаруй хувийг банкны салбар дангаараа бүрдүүлж байсан бол сүүлийн жилүүдэд банкнаас бусад санхүүгийн салбарууд болох хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл болон бичил санхүүгийн салбар хурдацтайгаар өсөж хөгжин нийт санхүүгийн систем дэх банкны салбарын төвлөрөл саарч байна. Энэхүү өөрчлөлтөд технологийн дэвшлийн нөлөө чухал ач холбогдолтой. Технологийн дэвшлийн нөлөөгөөр хэрэглэгчид санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг амар хялбар хүртэхээс гадна зах зээл дээр хэрэглэгчдийн санхүүжилтийн хэрэгцээ, шаардлагад тохирсон олон шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтэрч байна. Түүнчлэн санхүүгийн дэд салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагаа улам бүр нэмэгдэж буй бөгөөд хэрэглэгчид гар утасны ганцхан аппликейшнийг ашиглан төлбөр тооцоо, хөрөнгө оруулалт, даатгал, болон зээлийн үйлчилгээг нэг дор хүртэх боломжууд нэмэгдэж буй юм.

Монгол Улсын санхүүгийн системд нийт 12 арилжааны банк тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд нэг арилжааны банк нь бүрэн цахим буюу нео банк хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг бол үлдсэн 11 арилжааны банкнуудын хувьд интернэт болон мобайл банкаар дамжуулан хэрэглэгчдэд цахим үйлчилгээ үзүүлдэг болоод нэлээдгүй хугацааг үдэж байна.

Зураг 1. Монгол Улсын финтек зах зээлийн экосистем

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Технологийн дэвшлийн нөлөө хамгийн өндөр санхүүгийн үйлчилгээ нь төлбөр, тооцооны үйлчилгээ бөгөөд дэлхий даяар зах зээл дэх бэлэн мөнгөний хэрэглээ жил ирэх тусам хурдацтайгаар буурах хандлагатай байна. Монгол Улсын тухайд ч мөн адил иргэдийн бэлэн мөнгөний хэрэглээ жил ирэх тутам буурч буй бөгөөд 2020 оны жилийн эцсийн байдлаар гэхэд нийт гүйлгээн дэх бэлэн мөнгөний гүйлгээний тоо 16 хувьтай байна. Энэхүү үзүүлэлт нь 2016 онд 45 хувьтай байсан бөгөөд сүүлийн жилүүдэд эрчимтэй буурч буй юм (Монголбанк, 2022). Цахимаар хийгдэж буй гүйлгээний дийлэнх хувийг интернэт банк болон мобайл банкаар хийгдэж буй гүйлгээ бүрдүүлж буй хэдий ч сүүлийн жилүүдэд иргэд хувийн хэвшлээс зах зээлд нийлүүлж буй цахим мөнгө, мөн банкнаас бусад санхүүгийн салбарын оролцогчид, технологийн компаниудын хөгжүүлж буй цахим хэтэвч, төлбөр тооцооны хэрэгслийг ашиглах хандлага нэмэгдэж байна. Өнөөгийн байдлаар Монголбанкнаас цахим мөнгө, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах тусгай зөвшөөрөлтэй нийт 7 компани зах зээлд цахим хэтэвч, төлбөрийн хэрэгслийн үйлчилгээг эрхэлж байна.

Түүнчлэн финтекийн хөгжил хамгийн амжилттай нэвтэрч буй салбар нь банк бус санхүүгийн байгууллагын салбар тэр дундаа зээлийн үйлчилгээ бөгөөд нийт 42 банк бус санхүүгийн байгууллага гар утасны аппликейшнд суурилсан финтек зээлийн үйлчилгээг эрхэлж байна. Финтек зээлийн давуу тал нь бүрэн цахимаас гадна хэрэглэгчдийн богино хугацаат, бага дүнтэй санхүүжилтийн эрэлт, хэрэгцээг ямар нэгэн барьцаа хөрөнгө шаардахгүйгээр хурдан шуурхай шийдэж буй явдал юм.

Зураг 2. Банк бус санхүүгийн байгууллагын финтек зээлийн статистик



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2023 оны 2 дугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын салбарын зээлдэгчдийн тоо 1.3 саяд хүрсэн бөгөөд үүний 93 хувийг финтек зээлдэгчид бүрдүүлж байна. Мөн салбарын нийт зээлийн үлдэгдэл 3.1 их наяд төгрөг хүрснээс 4.2 хувийг финтек зээлийн үлдэгдэл эзэлж байна. Салбарын хэмжээнд нийт олгосон зээлийн 19.2 хувийг, төлөгдсөн зээлийн 20.5 хувийг мөн тус тус финтек зээлийн үйлчилгээ бүрдүүлж буй юм.

Зээлийн салбарт технологийн дэвшлийг ашиглан P2P, хамтын санхүүжилт болон худалдан аваад дараа нь төл (buy now pay later) үйлчилгээнүүд шинээр нэвтэрч байна. P2P зээл болон хамтын санхүүжилтийн үйлчилгээнүүдийн хувьд сэндбокс зохицуулалтын орчинд хамрагдан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ туршиж байгаа бол худалдан аваад дараа нь төлөх нөхцөл бүхий үйлчилгээний хувьд санхүүгийн зохицуулалтад хамаарахгүйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөрөнгийн зах зээл, болон даатгалын зах зээлийн оролцогчид мөн өөрсдийн үйлчилгээг хэрэглэгчдэд цахимаар хүргэж эхэлсэн бөгөөд

2023 оны 2 дугаар улирлын байдлаар хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг нийт 52 үнэт цаасны компаниас 18 нь цахим үйлчилгээг нэвтрүүлэн хөрөнгө оруулагчдад үнэт цаасны дансаа цахимаар нээх, мөн хөрөнгийн зах зээлийн арилжаанд гар утасны аппликейшн болон цахим хуудсаа ашиглан шууд оролцох боломжийг бүрдүүлсэн байна. Даатгалын салбарын хувьд ердийн даатгалын нийт 16 компани байгаагаас 8 нь цахим үйлчилгээг нэвтрүүлэн иргэдэд даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг цахимаар борлуулж байна.

Зураг 3. Виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Сүүлийн жилүүдэд санхүүгийн зах зээлд тохиосон хамгийн том өөрчлөлтүүдийн нэг нь виртуал хөрөнгө, болон криптовалютын зах зээл бөгөөд уг зах зээл Монгол Улсын санхүүгийн салбарт ч мөн хурдтайгаар нэвтрэн хөгжиж байна. Монгол Улсын хувьд виртуал хөрөнгийн үйлчилгээ эрхлэгчид буюу биржүүдийг хянаж зохицуулдаг бөгөөд өнөөгийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй нийт 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ эрхлэгч байгаа бөгөөд дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 263.9 тэрбум төгрөг байна.

Дотоодын виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдээр дамжин 211 нэр төрлийн виртуал хөрөнгө арилжаалагдаж буй бөгөөд эдгээрийн 19 хувь нь буюу 41 нь дотоодын виртуал хөрөнгө байна.

Технологийн дэвшлийг ашиглан санхүүгийн системд шинээр нэвтэрч буй нэг үйлчилгээ нь цахим платформд суурилсан мөнгөний захын бирж юм. Тус биржээр банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн багцаар баталгаажсан репо хэлцэл, итгэлцэл болон хадгаламжийн сертификатад суурилсан мөнгөний захын хэрэгсэл арилжаалагдан сэндбоксын орчинд туршигдаж байна. 2023 оны 2 дугаар улирлын байдлаар уг платформоор дамжин нийт 705 удаагийн хэлцлээр 118.4 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

2.2. БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

Монгол Улсын Их Хурлын 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа– 2050”

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод ухаалаг санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх бодлогын зорилт тусгагдсан байдаг бөгөөд цахим технологид суурилсан, ухаалаг санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын нэгэн чухал хэсэг нь юм.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2022 онд Санхүүгийн зохицуулах хорооны даргын 469 дүгээр тушаалаар “Санхүүгийн зохицуулах

хорооны стратеги төлөвлөгөө (2022–2025)”–г батлан хэрэгжүүлж буй бөгөөд тус стратеги төлөвлөгөөнд Санхүүгийн зохицуулах хорооны эрхэм зорилго нь “олон тулгуурт, хүртээмжтэй, цахим технологид суурилсан санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ” гэж тодорхойлсон. Түүнчлэн уг стратеги төлөвлөгөөнд “уян хатан зохицуулалт, цахим технологид суурилсан санхүүгийн зах зээлийг дэмжих” гэж тусгасан байдаг. Энэхүү эрхэм зорилго болон стратегийн зорилтынхоо хүрээнд технологид суурилсан санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжсэн хууль, эрх зүй, бодлого зохицуулалтын орчныг бүрдүүлэх, санхүүгийн хяналт, шалгалт, зохицуулалтын үйл ажиллагаанд мөн цахим технологийг нэвтрүүлэх зэргийг төлөвлөн ажиллаж байна.



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АЛСЫН ХАРАА

Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн итгэлийг хүлээсэн ухаалаг санхүүгийн зах зээлийг цогцлооно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Олон тулгуурт, хүртээмжтэй, цахим технологид суурилсан санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

Сүүлийн жилүүдэд санхүүгийн зах зээлийн бодлого, зохицуулалтын орчинд нэлээд түгж буй бодлогын хэрэгсэл нь технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, инновацыг хязгаарлагдмал хүрээнд бодит орчинд турших боломжийг олгодог сэндбоксын зохицуулалт бөгөөд Монгол Улсын санхүүгийн зах зээлийн хувьд 2021 оны 3 дугаар сард Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн байгууллагуудын хамтарсан тушаалаар “Сэндбокс зохицуулалтын орчны журам”–ыг баталж, уг зохицуулалтын арга хэрэгслийг нэвтрүүлсэн.



2021 оны 12 дугаар сарын 17–ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд “технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг хязгаарлагдмал хүрээнд бодитоор турших, нэвтрүүлэх сэндбокс зохицуулалтын орчныг бий болгох, холбогдох зохион байгуулалтын нэгж, зөвлөл байгуулах зэрэг харилцааг зохицуулсан сэндбокс зохицуулалтын журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгчтэй хамтран батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих” заалтыг тусгасан. Санхүүгийн зохицуулах хороо нь сэндбоксод бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших хүсэлтийг хүлээн авах, сэндбоксын орчинд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ туршиж буй компаниудтай хамтран ажиллах, холбогдох зөвлөгөө, мэдээллээр хангах чиг үүрэг бүхий “Сэндбоксын алба”–ыг 2022 оны 4 дүгээр сард байгуулан сэндбоксод орох хүсэлтийг хүлээн авч эхэлсэн.

2023 оны 2 дугаар улирлын байдлаар сэндбокс зохицуулалтад өөрсдийн хөгжүүлж буй шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг турших нийт 15 хүсэлт ирсэн бөгөөд эдгээрээс 5 нь сэндбоксын орчинд орон 1 үйлчилгээ нь нэг жилийн хугацаагаар туршигдан сэндбоксын орчноос гарч, 4 үйлчилгээ нь туршигдаж байна.

Зураг 4. Сэндбоксын орчинд орохоор ирүүлсэн хүсэлт, үйлчилгээний төрлөөр

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Эдгээр 4 үйлчилгээ нь санхүүгийн зах зээл дээрх богино хугацаат эх үүсвэрийн хэрэгцээг хангах онцлог бүхий банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн багцаар баталгаажсан репо хэлцэл, банкны хадгаламжийн сертификат болон банк бус санхүүгийн байгууллагын итгэлцлийн үйлчилгээнд суурилсан мөнгөний захын хэрэгслийг арилжаалдаг мөнгөний захын бирж, мөн хиймэл оюун ухаанд суурилсан зээлийн үнэлгээ бүхий P2P зээлийн платформ, төслийн санхүүжилтийг дэмжих хамтын санхүүжилтийн үйлчилгээ, болон эрсдэлийн газрын зураглалд суурилсан инсуртекийн үйлчилгээ зэрэг болно.

Монгол Улсын санхүүгийн салбарт дараах голлох хуулиуд болон бусад холбогдох хууль, дагалдан батлагдсан журам, заавар, аргачлалууд мөрдөгддөг бөгөөд цахим технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн болон цахимаар хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцаанууд салбарын хууль, дүрэм, журмуудад тусгагдаж байна.

Хүснэгт 1. Санхүүгийн салбарын голлох хуулиуд, цахим үйлчилгээтэй холбоотой харилцааг тусгасан байдал

№	Хуулиудын нэр	Цахим санхүүгийн үйлчилгээтэй холбоотой заалт туссан эсэх
1	Төв банк /Монголбанк/-ны тухай хууль	-
2	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль	Сэндбокс зохицуулалттай холбоотой харилцаа туссан.
3	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль	Цахим мөнгө, шилжүүлэг, виртуал хөрөнгө болон технологид суурилсан санхүүгийн харилцаатай холбоотой харилцаа туссан.
4	Үндэсний төлбөрийн системийн тухай хууль	Цахим мөнгө гаргах, мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэгтэй холбоотой харилцаа туссан.
5	Банкны тухай хууль	Банкны мэдээллийн технологийн шалгуур үзүүлэлтийн журам болон холбогдох журмаар цахим банкны харилцааг зохицуулдаг.

6	Даатгалын тухай хууль	Даатгалын багц дүрэмд цахим даатгалын үйлчилгээтэй холбогдох харилцааг тусгасан.
7	Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль	Даатгалын зуучлалыг цахимаар үзүүлэхтэй холбоотой харилцаа даатгалын багц дүрэмд туссан.
8	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль	Үнэт цаасны багц дүрэмд үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд нь цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх программ хангамжтай байх шаардлагыг тусгасан.
9	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль	Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журамд финтек зээлийн үйлчилгээтэй холбогдох харилцаа туссан.
10	Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль	Цахимаар данс нээх, хаах, гэрээ байгуулах, үйлчилгээ авахтай холбоотой харилцаа туссан.
11	Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль	-
12	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль	Виртуал хөрөнгийн үйлчилгээ эрхлэгчтэй холбоотой харилцаа туссан.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Технологид суурилсан санхүүгийн үйл ажиллагаануудын хувьд санхүүгийн системд мөрдөгдөж буй хууль, дүрэм журмуудаас гадна цахим хөгжил, харилцаа холбооны салбарт мөрдөгдөж буй хууль, дүрэм, журмууд стандартууд мөн мөрдөгдөх шаардлагатай бөгөөд дараах хуулиуд холбогдох зохицуулалтын хүрээнд санхүүгийн системд ашиглагдаж байна.

Хүснэгт 2. Цахим хөгжлийг дэмжих хуулиуд

№	Хуулиудын нэр	Санхүүгийн үйлчилгээтэй холбоотой зохицуулалт бий эсэх
1	Инновацын тухай хууль	Гарааны компани үнэт цаас гаргахтай холбоотой харилцаа туссан.
2	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль	Төрийн байгууллагуудын мэдээлэл мэдээллийн ил тод байдал, цахим үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулдаг.
3	Цахим гарын үсгийн тухай хууль	Цахим гарын үсэг, тоон гарын үсэг, цахим тамгатай холбоотой харилцааг зохицуулдаг.
4	Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль	Хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, ашуулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулдаг.
5	Кибер аюулгүй байдлын тухай хууль	Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны тогтолцоо, зарчим, эрх зүйн үндсийг тогтоох, кибер орон зай, кибер орчин дахь мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Эх сурвалж: Цахим хөгжил, харилцаа холбооны яам

Санхүүгийн системийн хяналт, зохицуулалтыг ерөнхийд нь институционал суурьтай болон үйл ажиллагаанд суурилсан гэж хоёр ангилдаг. Институционал суурьтай зохицуулалтын хувьд санхүүгийн системд оролцогч байгууллагуудыг тус бүрд нь ялгаатай, хууль, эрх зүйн хүрээнд хянаж зохицуулдаг бөгөөд санхүүгийн системийн тогтвортой байдлыг хадгалах талаасаа уг аргачлал нь илүү давуу талтай байдаг. Харин үйл ажиллагаанд суурилсан зохицуулалтын хувьд санхүүгийн байгууллагуудад бус санхүүгийн үйл ажиллагаанд нь суурилсан хууль, эрх зүйн зохицуулалттай байдаг бөгөөд илүү уян хатан, инновац, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд амар хялбар байдлыг бий болгодог. Хэдийгээр зохицуулалтын уг хоёр хандлага нь өөрсдийн давуу болон сул талуудтай хэдий ч сүүлийн жилүүдэд улс орнууд аль, алиныг нь тодорхой түвшинд хослуулан хэрэгжүүлж байна. Тухайлбал АНУ, Англи, Европын холбоо, болон Австрали зэрэг улсууд хосолмол зохицуулалтыг хэрэгжүүлж байна.

Харин Монгол Улсын хувьд манай улс санхүүгийн үйл ажиллагааг биш санхүүгийн байгууллагуудад нь суурилан ялгаж зохицуулдаг бөгөөд энэ нь санхүүгийн хяналтыг нарийн тодорхой хэрэгжүүлэх, нийт системийн эрсдэлийг хянахад давуу талыг бий болгодог хэдий ч шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд хүндрэл үүсэж байна. Тухайлбал сүүлийн жилүүдэд технологийн дэвшлийн нөлөөгөөр зах зээлд шинээр нэвтэрч буй олон төрлийн санхүүгийн үйлчилгээг заавал банк, үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоодын салбарын аль нэгэнд хамааруулан зохицуулах нь тухайн бүтээгдэхүүний онцлогт нийцээгүй хатуу, уян хатан бус зохицуулалт болж байна. Гэхдээ 1995 онд батлагдан 2021 онд шинэчлэгдэн найруулагдсан “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль” болон 2022 онд батлагдсан “Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль” нь үйл ажиллагаанд суурилсан зохицуулалтын нэг хэлбэр бөгөөд цаашид санхүүгийн системийн хяналт, зохицуулалтын орчинд хосолмол чиг хандлага руу шилжих боломж буйг мөн харуулж байна.

Цаашид санхүүгийн зах зээлийн хууль, эрх зүй болон бодлого зохицуулалтын орчинд илүү уян хатан, системийн эрсдэл, кибер аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдлыг тусгасан харилцааг тусган сайжруулах, технологид суурилсан санхүүгийн компаниудад мөрдөгдөх технологийн шаардлага, холбогдох зохицуулалтуудыг тусгах мөн санхүү болон харилцаа холбооны салбарын зохицуулалтын нийцлийг сайжруулах зэрэг бодлогын орчныг ажлууд хийгдэх шаардлагатай юм.

III. ФИНТЕКИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ ОЛОН УЛСАД

3.1. ФИНТЕК САЛБАРЫН ЗАХ ЗЭЭЛ, ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ИРЭЭДҮЙ

2022 оны байдлаар дэлхийн финтекийн зах зээлийн үнэлгээ 194.1 тэрбум ам.долларoор үнэлэгдэж буй бөгөөд 2030 он гэхэд тус зах зээл 936.5 тэрбум ам.доллар хүрч өсөх төлөвтэй байна. Саяхныг хүртэл финтекийн салбарт Хойд Америкийн зах зээл тэр дундаа АНУ финтекийн салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалт, инновацыг дэмжсэн бодлогын орчны нөлөөгөөр тэргүүлдэг байсан бол ирээдүйд тус салбарт Ази, Номхон далайн бүс нутаг тэр дундаа Зүүн өмнөд Азийн улсууд, Энэтхэг, Хятад улсуудын зах зээл тэргүүлэх хүлээлттэй байна. “Бостон Консалтинг Групп”–ийн тооцооллоор 2030 он гэхэд нийт финтекийн салбарын жилийн орлого 1.5 их наяд ам.доллар хүрэх бөгөөд үүний 42 хувийг Ази, номхон далайн бүс нутаг дангаар бүрдүүлнэ гэсэн хүлээлттэй байна.

Зураг 5. Финтекийн салбарын жилийн орлого, өсөлтийн таамаглал



Эх сурвалж: Бостон консалтинг групп

Финтекийн хөгжлийн дийлэнх үе нь төлбөрийн систем, төлбөр тооцооны үйлчилгээний хувьслаар тодорхойлогдож ирсэн. 2021 онд л гэхэд нийт финтекийн салбарын орлогын 40 хувь нь төлбөр, тооцооны үйл ажиллагаанаас орж ирсэн бол цаашид ч төлбөр, тооцооны салбар финтекийн салбарт тэргүүлэх байраа хадгалах хүлээлттэй байна. Мөн технологид суурилсан зээл, даатгалын үйлчилгээний салбар 2030 он хүртэл финтекийн салбарын дараагийн голлох

тоглогчид байна хэмээн судлаачид үзэж байна.

Түүнчлэн B2B2X бизнес загвар финтекийн салбарын хөгжлийн чиг хандлагыг ирэх жилүүдэд тодорхойлох бөгөөд B2B2X шийдэл нь санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, хэрэглэгчдэд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ үр ашигтай хүргэх боломжийг нь олгох зорилготой. B2B2X үйлчилгээний зах зээлийн жилийн өсөлт 25 орчим хувьтай байхаар хүлээгдэж буй бөгөөд 2030 он гэхэд тус үйлчилгээний жилийн орлого 440 ам.долларт хүрнэ гэсэн тооцоолол гарсан.

Угсармал санхүүгийн үйлчилгээ (Embedded Finance) нь B2B2X үйлчилгээний нэг хэлбэр бөгөөд санхүүгийн үйлчилгээ, санхүүгийн хэрэгслийг санхүүгийн бус байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээнд шигтгэсэн үйлчилгээ юм. Сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж буй одоо аваад дараа төл үйлчилгээ нь угсармал санхүүгийн үйлчилгээний нэг жишээ юм.

Санхүүгийн зах зээлд ихээхэн ашиглагддаг эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн менежмент, бизнес аналатикс, андеррайтинг зэрэг санхүүгийн салбарын дэд бүтцийн шийдлүүд нь мөн B2B2X загварын нэг төрөл бөгөөд технологийн дэвшил, их өгөгдөлд суурилсан эдгээр төрлийн үйлчилгээг банк, санхүүгийн байгууллагууд ашиглан өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг илүү үр ашигтайгаар хэрэглэгчдэд хүргэх боломж бүрдэж буй юм.

Зураг 6. Санхүүгийн салбарт тэргүүлэх бизнес салбаруудын орлого, өсөлтийн таамаглал



Эх сурвалж: Бостон консалтинг групп

B2B бизнесийн зах зээлд мөн өсөлтийн өндөр боломж бий. Дэлхийн эдийн засгийн форумын гаргасан судалгаагаар жижиг дунд, үйлдвэрлэлийн зах зээл нь дэлхийн нийт ДНБ, ажил эрхлэлтийн 70 орчим хувийг бүрдүүлдэг бөгөөд дэлхий даяар нийт 400 сая гаруй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид үйл ажиллагаагаа явуулдаг. B2B бизнес загвар тэр дундаа B2B

төлбөр тооцоо, зээлийн үйлчилгээ нь жижиг дунд үйлдвэрлэлийн санхүүжилтийг шийдэх хамгийн оновчтой шийдлүүдийн нэгт тооцогдож буй бөгөөд 2030 он гэхэд B2B финтекийн салбар жилийн 32 хувийн өсөлттэйгөөр 285 тэрбум ам.долларын зах зээлийг эзлэх тооцоолол гарсан.

Финтекийн салбарын ирээдүйг тодорхойлох дараагийн нэгэн хандлага нь нээлттэй санхүү (open financing) юм. Нээлттэй санхүү нь хэрэглэгчдийн мэдээлэл санхүүгийн байгууллагууд дунд нээлттэй ашиглагдсанаар хэрэглэгчид өөрсдийн хэрэгцээ, шаардлага, эрсдэлд тохирсон төрөл бүрийн санхүүгийн бүтээгдэхүүнийг нэг дороос авах боломжийг олгох юм. Мөн нээлттэй санхүүгийн цаашдын ирээдүйд санхүүгийн байгууллагууд хэрэглэгчдийн зөвхөн санхүүгийн мэдээллээс гадна эрүүл мэнд, боловсрол болон бусад төрлийн төрд хадгалагдаж буй мэдээлэлтэй холбосноор хэрэглэгчдийн эрсдэл болон санхүүгийн чадавхыг илүү нарийн үнэлэн бүтээгдэхүүнээ санал болгоно.

3.2. ФИНТЕК САЛБАРЫН ЗОХИЦУУЛАЛТ

Дэлхийн санхүүгийн хямралаас хойших арав гаруй жилийн хугацаанд санхүүгийн системд мөрдөгддөг хууль, журам, стандартууд болон салбаруудын хяналт, зохицуулалтын үйл ажиллагаа чангарсан.

Банк, санхүүгийн салбарын зохицуулалт нь хөрөнгийн чанар, төлбөрийн болон хөрвөх чадвар, гэнэтийн эрсдэлийн үеийн бодлого, зохицуулалт, макро болон микро зохистой бодлого, системийн эрсдэлийн бодлого, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, засаглал, хүний нөөцийн бодлого зэрэг олон төрөлд хөгжин хэрэгжиж байна.

Ирэх арван жилийн хувьд ч мөн адил санхүүгийн системийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагаа улам бүр эрчимжих хандлагатай байна. Гэхдээ энэ удаад ямар нэгэн санхүүгийн хямрал, системийн хэмжээний уналт бус финтекийн хурдтай хөгжил, түүнийг дагасан мэдээллийн болон кибер аюулгүй байдлын эрсдэл, мөн уур амьсгалын өөрчлөлт санхүүгийн хяналт, зохицуулалтын хувьслыг тодорхойлно.

Санхүүгийн салбар дахь технологийн хувьсал санхүүгийн зах зээл, эдийн засаг болон нийгэмд олон тооны шинэ боломжуудыг авчирч буй хэдий ч хурдтай өрнөж буй хувьслыг даган мөн олон тооны сорилтууд гарч ирж байна.

Хүснэгт 3. Финтекийн зах зээлийн боломж ба сорилт

	БОЛОМЖ		СОРИЛТ
1	Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үр ашигтай хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх		Зохицуулалтын хязгаарлалт, зохицуулалтын орчны тодорхой бус байдлаас үүдсэн өндөр зардал
2	Их өгөгдөл болон өгөгдлийн шинжилгээний ашиглалт		Өгөгдлийн нууцлал, аюулгүй байдал, буруу ашиглалт, хариуцлагагүй бизнесийн үйл ажиллагаа явуулах
3	Хиймэл оюун ухаан, машин сургалтын ашиглалт		Хар хайрцгийн эрсдэл, шинээр үүсэж буй эрсдэлийг танилгүй хугацаа алдах
4	Технологийн платформуудад суурилсан бизнес загвар		Шударга бус өрсөлдөөн гарах, зах зээлийн төвлөрөл үүсэх, санхүүгийн тогтвортой байдлын эрсдэл үүсэх
5	Хэрэглэгч бүрд тохирсон санхүүгийн үйлчилгээ		Мэдээллийн тэгш бус байдал үүсэх, хэрэглэгчид санхүүгийн харилцаанд хариуцлагагүй орох
6	Санхүүгийн хяналт, зохицуулалтын технологи		Зохицуулалтын хэрэгслүүдийг нийгмийн илүү өргөн хүрээний асуудлуудыг шийдэхэд зориулан ашиглах. ЖДҮ–ийг дэмжих, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх гэх мэт

Санхүүгийн салбарын хяналт, зохицуулалт харин эдгээр сорилт, эрсдэлийг бууруулан технологийн дэвшлийн өгөөжийг боломжит хэмжээнд нь ашиглахыг зорих шаардлагатай ба ирэх жилүүдэд санхүүгийн хяналт, зохицуулалтад дараах өөрчлөлтүүд гарна гэж судлаачид таамаглаж байна:

- Санхүүгийн дэд салбар хоорондын ялгаа буурах, санхүүгийн салбарт санхүүгийн бус оролцогчид ихээр орж ирж буй тул санхүүгийн салбарын зохицуулалт аливаа нэг салбар, санхүүгийн байгууллагад төвлөрсөн бус үйл ажиллагаанд төвлөрсөн зохицуулалт руу шилжих;
- Санхүүгийн үйл ажиллагаа хурдтайгаар өөрчлөгдөж буй бөгөөд үүнийг дагасан зохицуулалтын өөрчлөлтийг холбогдох хууль, журамд тусгахад хугацаа их алдах учир дүрэмд суурилсан санхүүгийн зохицуулалтаас зарчимд суурилсан загварлуу шилжих;
- Технологийн дэвшил санхүүгийн хяналт, зохицуулалтад ч мөн адил хурдтай нэвтэрч буй учир нарийвчилсан хяналт, шалгалт,

зохицуулалтын стандартаас илүү салбарыг бүхэлд нь харсан, тогтвортой байдлыг хангасан хяналт зохицуулалт руу шилжих;

- Санхүүгийн салбар хил дамнан хөгжиж буй учир олон улсад нийтлэг мөрдөгддөг стандарт, зохицуулалтуудад төвлөрөн зохицуулалтын орчноо бүрдүүлэх, ингэхдээ санхүүгийн салбар дахь жижиг оролцогчдын үйл ажиллагаа, онцлогийг мөн харгалзах, ялгаатай зохицуулалтыг тусгах;
- Томоохон технологийн компаниудын санхүүгийн салбар дахь оролцоо өндөр байх тул зах зээлийн өрсөлдөөний зохицуулалтыг тусгах, монопол шинжтэй болон өрсөлдөөнт бус зах зээл үүсэхээс сэргийлсэн зохицуулалтыг бүрдүүлэх;
- Санхүүгийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэх үүднээс санхүүгийн зохицуулагч байгууллагууд технологийн компаниудыг хөлслөн ажиллах, хувийн байгууллагуудтай хамтран ажиллах хэрэгцээ шаардлага нэмэгдэх;
- Санхүүгийн болон технологийн зохицуулагч байгууллагууд зохицуулалтын дүрэм, журам болон стандартуудаа нийцүүлэх зэрэг болно.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд улс орнууд санхүүгийн зах зээл дэх финтекийн хөгжил, инновацын хөгжлийг дэмжих төрөл бүрийн хурдасгуурыг ашиглаж байгаа бөгөөд хамгийн түгээмэл хэрэглэгдэж буй хурдасгууруудад зохицуулалтын сэндбокс, инновацын хаб, инкубатор төв, засгийн газрын санал, санаачилга, стратегиуд зэрэг багтаж байна.

3.3. ИННОВАЦЫН ХАБЫН ХӨГЖИЛ ОЛОН УЛСАД

Дэлхий даяар санхүүгийн зохицуулагч байгууллагууд, салбарын бодлого гаргагчид финтекийн хөгжлийг дэмжих, санхүүгийн салбар дахь инновацыг хурдасгах зорилгоор инновацын хурдасгуур бодлогын хэрэгслүүдийг эрчимтэй нэвтрүүлж байна. Тухайлбал 2023 оны II улирлын байдлаар дэлхийн 95 улс санхүүгийн салбар дахь инновацын хурдасгууруудын нэг болох сэндбокс зохицуулалтыг үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна. Технологийн хөгжил эрчимжихийн хэрээр эдгээр технологийн дэвшлийг боломжит хэмжээнд нь үр ашигтайгаар ашиглах, үүсэж болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлон, зах зээлийн тогтвортой байдлыг хангах чиглэлийн судалгаанууд тасралтгүй хийгдсээр байгаа бөгөөд эдгээр судалгаанууд нь инновацын хаб болон сэндбокс зохицуулалтыг хамгийн үр дүнтэй, түгээмэл инновацын хурдасгуураар нэрлэж байна. Түүнчлэн сэндбокс зохицуулалт эсхүл инновацын хаб нь дан дангаар төдийлөн үр ашигтай ажиллахгүй байх талтай тул зохицуулах байгууллагууд сэндбоксыг бүрдэл хэсгээ болгосон инновацын хабыг байгуулах нь зүйтэй гэсэн судалгааны үр дүнгүүд ч гарч байна (Buckley, Arner, and Veidt, 2020).

Сэндбоксын зохицуулалт нь олон улс орнуудад тархан финтекийн эко системд ашиглагдаж буй түгээмэл хэрэгсэл болж буй ч инновац хөгжүүлэгчид, санхүү, технологийн компаниудад сэндбоксод оролцохоос гадна санхүүгийн зах зээлийн зохицуулалтын орчин,

мөрдөх стандартуудтай холбоотой зөвлөгөө, заавар авах, салбарыг хөгжүүлэх чиглэлд нягт хамтран ажиллах бодлогын хэрэгсэл дутагдаж буйг мөн онцлох болсон. Инновацын хаб нь уг асуудлыг шийдвэрлэхэд туслах эхлэлийн цэг болж байна гэж зарим судлаачид, бодлого гаргагчид үзэж байна.

Зураг 7. Инновацын хаб болон сэндбоксын тархалт



Эх сурвалж: Дэлхийн банк, ОУВС, Кэмбриджийн уламжлалт бус санхүүжилтийн төвийн судлаачдын тооцоолол

"StartUs Insights"–аас хийсэн судалгаагаар 2020 оны 7 дугаар сарын байдлаар дэлхий даяар нийт 61 финтекийн инновацын хаб үйл ажиллагаа явуулан дижитал банк, санхүү, регтек, суптекийн шийдлүүдийг хөгжүүлэх чиглэлд ажиллаж байна. Эдгээр инновацын хаб нь финтек компаниуд болон санхүүгийн салбар дахь гарааны бизнесүүдийг дэмжих, хөрөнгө оруулагч болон финтек компаниудыг холбох, финтекийн хөгжлийг дэмжих болон регтек, суптекийн салбарыг хөгжүүлэх зэрэг ялгаатай зорилго, зорилтуудын хүрээнд хөгжиж байна. Эдгээрээс Английн Санхүүгийн зохицуулах хороо, Сингапурын Төв банкны хөгжүүлж буй инновацын хабууд болон Базелийн хорооноос регтек, суптекийн чиглэлд хөгжүүлсэн инновацын хабууд хамгийн алдартай нь юм.

"FCA Инновацын Хаб"– Англи Улсын Санхүүгийн зохицуулах хороо

Англи Улсын Санхүүгийн зохицуулах хороо нь Инновацын Хабын төслөө 2014 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2016 онд Сэндбокс, 2020 онд Дижитал сэндбоксыг тус тус нэвтрүүлэн ажиллаж байна.

Зураг 8. Англи Улсын инновацын хабын хөгжил



Эх сурвалж: Английн санхүүгийн зохицуулах хороо

FCA Инновацын хабын голлох үйл ажиллагаа нь финтек компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг зохицуулалт талаас дэмжих, зохицуулалтын технологи буюу регтекийн хөгжлийг дэмжих, салбарын оролцогчдын харилцаа, холбоог сайжруулах мөн санхүүгийн салбарын инновацын талаарх судалгаа, шинжилгээг хөгжүүлэх зэрэгт чиглэсэн.

Инновацын хабын голлох үйлчилгээнүүд:

- Зохицуулалтын сэндбокс – санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, инновацын шийдлийг бодит зах зээлд туршихад чиглэсэн;
- Инновацын мэдээллийн суваг – санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийн шийдэлтэй холбоотой зохицуулалтын орчны талаарх зөвлөгөө, мэдээллээр хангах, английн зах зээлд нэвтрэх гэж буй гаднын финтек компаниудыг зөвлөгөө, мэдээллээр хангах үүрэгтэй;
- Дижитал сэндбокс – хөгжлийн эхэн үедээ буй гарааны бизнесүүдийг өгөгдлөөр ханган өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээ шинэ санаагаа хөгжүүлэх, турших боломжийг олгосон орчин;
- Регтек хөгжүүлэлт – санхүүгийн зохицуулалт дахь технологийн хөгжлийг дэмжих зорилготой, хабын зүгээс тодорхой хүрээний регтек, суптекийн шийдлүүдийг хөгжүүлэх уралдаан болон бусад төрлийн хөтөлбөрийг зохион байгуулдаг;
- Хамтын ажиллагаа – финтекийн хөгжлийг дэмжих чиглэлд оролцогч талуудын хамтын ажиллагааны гүүр болдог. “Дэлхийн санхүүгийн инновацын сүлжээ” болон “инновацын зөвлөх групп”–ийг үүсгэн байгуулсан ба гадаад болон дотоод хамтын ажиллагааг тус 2 сувгаар дамжуулан ажилладаг;
- Мэдлэг, судалгааны хаб – санхүүгийн салбарт шинээр нэвтэрч буй технологи, тэдгээрийн зах зээл болон хэрэглэгчдэд үзүүлэх нөлөөг судлах зорилготой бодлого гаргагчид, эрдэмтэн, судлаачдын төлөөллөөс бүрдсэн судалгааны хабыг ажиллуулдаг мөн технологийн хөгжлийг дэмжих уралдаан, TechSprint–г тогтмол зохион байгуулдаг.

FCA Инновацын хаб нь 2014 онд байгуулагдсан цагаасаа хойш нийт 2400 гаруй хүсэлт хүлээн авч, 867 санхүү, технологийн компаниудад үйлчилгээ үзүүлж, сэндбокс орчиндоо 168

бүтээгдэхүүн, үйлчилгээг туршсан байна.

Англиийн Инновацын хаб нь засаглалын хувьд бүхэлдээ Санхүүгийн зохицуулагч хороондоо хамаардаг бөгөөд тус байгууллагын нэг газар нь болон үйл ажиллагаа явуулдаг. Санхүүгийн зохицуулах хорооны Инновацын газар нь нийт 120 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна. Инновацын газар нь дотроо инновац хэлтэс, регтек болон ахисан түвшний шинжилгээний хэлтэс, төв өгөгдлийн хэлтэс гэсэн гурван хэлтэстэйгээр үйл ажиллагаа явуулдаг. Инновац хэлтэс нь сэндбокс болон инновац хэрэгжүүлэгчдийг зөвлөгөө, мэдээллээр хангах чиг үүргэтэй, регтек болон ахисан түвшний шинжилгээний хэлтэс нь регтек болон суптекийн хэрэгслүүдийг хөгжүүлэн Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаанд технологийг нэвтрүүлэх ажлыг хариуцдаг.

Инновацыг хэрэгжүүлэх, санхүүгийн ахисан түвшний технологийг нэвтрүүлэх, өгөгдлийн системийг сайжруулах зэрэг бүхий л ажлыг цогцоор нь нэг газарт буюу инновацын хабд өгсөн нь Англиийн Санхүүгийн зохицуулах хороо болон тус улсын санхүүгийн зах зээлийн инновацын амжилтын нэг түлхүүр нь гэж судлаачид үздэг (Amy Friend, 2021).

"Сингапурын Инновацын хаб"– Сингапур Улсын төв банк

Сингапур Улсын финтек инновацын хабыг мөн Сингапурын Төв банк хариуцан хэрэгжүүлдэг бөгөөд Төв банкны бүтэц зохион байгуулалтад хамаарах Финтек болон Инновацын групп нь инновацын хабын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Тус группийн дор Төлбөрийн системийн хөгжүүлэлт, өгөгдлийн сангийн холболтын оффис, Финтекийн дэд бүтцийн оффис, Финтек экосистемийн оффис, Хиймэл оюун ухаан хөгжүүлэлтийн оффис, Ногоон финтекийн оффис зэрэг хэлтсүүд хамаардаг.

Сингапурын инновацын хабын гол үйл ажиллагаа нь:

- Зохицуулалтын зөвлөгөө, мэдээлэл: санхүүгийн салбарт инновац нэвтрүүлэгч байгууллагуудад холбогдох зөвлөгөө, мэдээллийг хангах үйлчилгээ;
- Зохицуулалтын сэндбокс: Сингапурын сэндбокс нь уламжлалт сэндбокс, сэндбокс экспресс, сэндбокс плас гэсэн гурван төрөлтэйгээр үйл ажиллагаа явуулдаг;

- Инновацын санхүүжилт: Сингапурын төв банк нь венчер хөрөнгө оруулалтын бизнес, ESG технологийн шийдэл, нийгэм, салбарын ач холбогдолтой финтекийн төслүүдэд 50 хүртэлх хувь, хиймэл оюун ухаан, өгөгдлийн шинжилгээний шийдэлд 30 хүртэлх хувь, үйл ажиллагаандаа дижитал шийдэл нэвтрүүлж буй болон төслөө турших хүсэлтэй компаниудад үйл ажиллагаанаас хамаарсан тодорхой хэмжээний санхүүжилт, болон татварын хөнгөлөлтүүдийг үзүүлдэг;
- Боловсрол, судалгааны төв: санхүүгийн инновацтай холбоотой сургалт, судалгааны үйл ажиллагаанууд болон Финтекийн фестиваль, воркшоп зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулдаг;
- Өгөгдлийн сангийн хөгжүүлэлт: тус инновацын хабд SGFinDex сингапурын санхүүгийн өгөгдлийн сүлжээг хөгжүүлдэг бөгөөд энд санхүүгийн байгууллагууд, төрийн байгууллагуудад буй хэрэглэгчдийн тоон өгөгдөл нэгтгэгддэг. Хэрэглэгчид өөрийн санхүүгийн харилцаанд хамаарах бүхий л мэдээллийг цахим иргэний үнэмлэхээрээ аван санхүүгийн шийдвэр гаргалтаа ухаалгаар гаргах боломж бүрдсэн;
- Технологийн хөгжүүлэлт: зөвхөн бодлогын үйл ажиллагаанаас гадна Сингапурын инновацын хабд төв банкны цахим валют, цахим төлбөр, тооцооны технологи, ЖДҮ–ийг дэмжих хиймэл оюун ухаанд суурилсан хамтын ажиллагааны платформ, ногоон финтекийн шийдлүүд зэргийг хөгжүүлдэг;
- Хувийн инновацын хабын зохицуулалт: Сингапур улсад хувийн инновацын хабууд мөн ажилладаг бөгөөд эдгээр хабуудын үйл ажиллагаанд хяналт тавин, хамтран ажилладаг.

Сингапурын инновацын хабт 50 гаруй инновацын лаборатори, 1300 гаруй финтекийн компаниуд хамрагдан нийт 4.1 тэрбум ам.долларын финтекийн хөрөнгө оруулалтыг авсан байна.

"BIS Инновацын Хаб" – Олон улсын төлбөр тооцооны банк

BIS инновацын хаб нь санхүүгийн систем мөнгөний болон санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн технологийн хөгжлийг дэмжихэд төв банкнуудад туслах зорилгоор үүсгэн байгуулагдсан.

Хабын голлох үйл ажиллагаа нь:

- Төв банкны цахим валютын хөгжүүлэлт;
- Суптек болон регтек хөгжүүлэлт;
- Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн хөгжүүлэлт;
- Нээлттэй санхүү;
- Кибер аюулгүй байдал;
- Ногоон санхүү зэргийг хөгжүүлэхэд чиглэсэн.

Тус инновацын хаб нь Европын холбоо (Франкпурт болон Парис), Хонконг, Лондон, Сингапур, Стогкольм, Швейцар зэрэг газруудад салбартай бөгөөд ажлын алба нь Базел хотод байрладаг. Харин засаглалын хувьд Олон улсын төлбөр тооцооны банкны дор шууд харьяалагддаг учир банкны удирдах зөвлөлийн гишүүдийн хяналт дор үйл ажиллагаа явуулдаг. BIS инновацын хаб нь 2021 оноос хойш нийт 25 төсөл хэрэгжүүлж буй бөгөөд эдгээр төслүүд нь төв банкны цахим валютын систем, төв банкны цахим валюттай улсуудын төлбөрийн системийн холболт, олон улсын төлбөрийн системийн технологи, санхүүгийн зах зээлийн хяналт, зохицуулалт, мөнгө угаах болон уур амьсгалын эрсдэлийн үнэлгээний системийг хөгжүүлэхэд чиглэсэн төслүүд байна.

IV. ИННОВАЦЫН ХАБ БАЙГУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

4.1. ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Технологийн хөгжил нь санхүүгийн зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдэд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг амар хялбараар хүргэх зэрэг боломжуудаас гадна хөгжиж буй улс орнуудад санхүүгийн зах зээл, эдийн засгийн хөгжлийн үе шат, цаг хугацааг товчлон өндөр хөгжсөн орнуудын эгнээнд нэгдэх боломжийг бий болгож байгаа билээ. Санхүүгийн салбар нь хүмүүсийн өдөр тутмын амьдралын хэрэгцээнээс гадна эдийн засаг, зах зээлийн үйл ажиллагааг явуулах гол суваг нь болж өгдөг тул нийгэм, эдийн засгийн хөгжлийн олон асуудал сайтар хөгжсөн санхүүгийн зах зээлийг даган шийдэгдэж байдаг.

Манай улсын хувьд зах зээлийн эдийн засагт шилжээд гуч гаруй жилийг үзэж буй бөгөөд санхүүгийн зах зээлийн хөгжил саяхныг хүртэл банкны системд төвлөрсөн хөгжлийн хувьд удаашралтай байсан. Харин сүүлийн жилүүдэд хурдтай тохиож буй финтекийн хувьсгал санхүүгийн салбарын өсөлт, хөгжилд эергээр нөлөөлж буй бөгөөд иргэд, олон нийт банкны үйлчилгээнээс гадна олон төрлийн санхүүгийн үйлчилгээг амар, хялбараар шийдэх боломж бүрдэж байна. Гэсэн хэдий ч хөгжиж буй улс орнуудад байдаг иргэдийн санхүүгийн мэдлэг, боловсролын түвшин, дэд бүтэц, хууль эрх зүйн орчны суурь сул зэрэг асуудлууд өнөөг хүртэл салбарын хөгжлийн гол гацаа болсоор байна. Эдгээр асуудлуудыг технологийн дэвшлийг ашиглан шийдэх, ухаалаг санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд инновацын хаб нь бодлогын чухал хэрэгсэл болно.

Инновацын хаб байгуулах хэрэгцээ, шаардлага:

- Эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэх, хөгжлийг дэмжих. Манай улс нь уул уурхайн бүтээгдэхүүнээс өндөр хамааралтай, далайд гарцгүй, ажиллах хүн багатай жижиг эдийн засагтай. Эдийн засгийн энэхүү нөхцөлөөс шалтгаалан хөдөлмөр ихээр шаардагддаг үйлдвэрлэл, худалдааны салбараас илүүтэйгээр технологи, капиталд суурилсан салбарууд илүү үр ашигтай юм. Санхүүгийн салбар нь эдгээр салбаруудын нэг бөгөөд финтекийн хөгжлийг дэмжсэнээр эдийн засгаа төрөлжүүлэх, мөн финтекийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, шийдлийг экспортлох бүрэн боломжтой юм.
- Санхүүгийн олон төрөлт үйлчилгээтэй, ухаалаг санхүүгийн төв болох. Монгол Улс банканд харилцах данстай хэрэглэгчдийн тоогоороо өндөр хөгжилтэй орнуудын эгнээнд ордог хэдий ч санхүүгийн бусад төрлийн үйлчилгээний хүртээмж хангалттай хэмжээнд хөгжөөгүй. 2022 онд Монголбанкнаас явуулсан “Иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшин тогтоох” судалгааны үр дүнгээс харахад иргэдийн дунд хамгийн түгээмэл санхүүгийн хэрэглээ нь мөнгө шилжүүлэх, харилцах данс ашиглах байсан бол хөрөнгө оруулалт, даатгалын бүтээгдэхүүний хэрэглээ хангалттай түвшинд хүрээгүй буюу 20 орчим хувьтай байна. Түүнчлэн насны бүтцээр нь авч харахад Z үеийнхэн буюу 24–өөс доош насныхны дунд цахим зээл, криптовалют зэрэг шинээр нэвтэрч буй санхүүгийн үйлчилгээний хэрэглээ хамгийн өндөр байна. Үүнээс үзэхэд ирэх жилүүдэд зах зээлд олон төрөлт санхүүгийн үйлчилгээний эрэлт их байхаас гадна, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүргэж чадвал зах зээлийн орон зай мөн их буй юм. Түүнчлэн сүүлийн жилүүдэд манай улсын финтек болон технологийн компаниуд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ Зүүн өмнөд ази, Төв азийн улсууд руу экспортлох болсон нь финтек бүтээгдэхүүний зах зээл зөвхөн манай улсаас гадна гадаад орчинд мөн эрэлттэй байхыг харуулж байна.
- Санхүүгийн хэрэглэгчдийн эрүүл мэнд, санхүүжилтийн өндөр өртөг. Монгол Улсын хувьд санхүүжилтийн өртөг өндөр бөгөөд инфляцын түвшнээс гадна эдийн засаг зах зээл дэх нөөц хөрөнгийн ашиглалт, зогсонги байдал, мөн үйлчилгээний зардал зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалан өртөг нь тогтож байдаг. Тийм учраас технологийн дэвшлийг ашиглан зах зээл дээрх мөнгөний эргэлтийг хурдасгах, нөөцийг үр ашигтайгаар зарцуулах шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх мөн санхүүгийн компаниудын зардлыг бууруулах технологийн шийдлийг нэмэгдүүлэх нь санхүүжилтийн өндөр өртгийг бууруулах нэг алхам болно. Түүнчлэн технологийн дэвшил, санхүүгийн үйлчилгээний амар хялбар байдлыг даган гарах нэг эрсдэл нь санхүүгийн хариуцлагагүй хэрэглээ байдаг бөгөөд иргэд зээлийн бүтээгдэхүүн ихээр хэрэглэн өрийн дарамтад орох, зээлийн нөхцөлийг сайтар судлалгүйгээр, төөрөгдсөн шийдвэр гаргах зэрэг олон сөрөг талууд сүүлийн жилүүдэд дэлхий дахинаа гарах болсон. Иймд хариуцлагатай санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид болон хэрэглэгчдийг бэлтгэх томоохон үүрэг зохицуулагч

байгууллагуудад тулгарч байна.

- Дижитал санхүүгийн боловсрол. Санхүүгийн боловсролын асуудлууд дээр технологийн боловсрол мөн нэмэгдэн орч ирж буй бөгөөд хэрэглэгчид шинэ тутам хөгжиж буй төрөл бүрийн цахим санхүүгийн үйлчилгээний талаар мэдлэг муутайгаасаа болон санхүүгийн залилангийн хохирогч болох цахим орчинд өөрсдийн хувийн мэдээллийг алдсанаар санхүүгийн хохирол амсах зэрэг олон үйл явдал сүүлийн жилүүдэд тохиож байна. Тухайлбал 2021 онд Цагдаагийн ерөнхий газарт бүртгэгдсэн 3 хэрэг тутмын нэг нь цахим залилантай холбоотой гэмт хэрэг байгаа нь цахим залилангийн асуудал манай улсын хувьд анхаарах асуудал болж буйг илтгэж байна. Иргэдийн цахим санхүүгийн боловсролыг олгох, хариуцлагатай хэрэглээг нэмэгдүүлэх, залилан, луйврын үйл ажиллагааг таних эрсдэлийн системийг боловсруулах зэрэг олон үйл ажиллагааг инновацын хабд хэрэгжүүлэх боломжтой юм.
- Финтекийн сургалт, судалгааны төвийн үүргийг гүйцэтгэх. Финтекийн хөгжил хурдацтайгаар өрнөн уламжлалт санхүүгийн системд томоохон өөрчлөлт тохиож буй. Уг хөгжлийг даган боловсон хүчнийг чадавхжуулах хэрэгцээ, шаардлага мөн нэмэгдэж байна. Сүүлийн жилүүдэд гадаадын их дээд сургуулиудад зөвхөн финтекийн чиглэлээр мэргэшсэн магистр, докторын хөтөлбөрүүд ихээр нээгдэн финтекийн дэд салбар бүрээрх сургалт, хөтөлбөрийн эрэлт ихээхэн өссөн. Харин манай улсын сургалтын хөтөлбөрт санхүүгийн технологийн талаарх агуулга хангалттай хэмжээнд тусгагдаагүй байдаг. Иймд санхүүгийн салбарын мэргэжилтнүүдийг бэлтгэх сургалт, судалгааны төв зайлшгүй хэрэгтэй юм.
- Регтек болон суптекийн хөгжүүлэлт. Зах зээлийн хөгжлийг дагаад санхүүгийн хяналт, зохицуулалтад технологийн дэвшлийг нэвтрүүлэх, мөн хянан шалгагчдын ачааллыг бууруулахад технологи ашиглах хэрэгцээ, шаардлага ихээхэн нэмэгдэж буй бөгөөд төрийн зохицуулагч байгууллагын хувьд уг шилжилт нь томоохон хэмжээний өөрчлөлтийг шаардсан тасралтгүй, цогц үйл ажиллагаа байдаг. Тийм ч учраас санхүүгийн зохицуулагч байгууллагуудын суптекийн шилжилтийг ихэвчлэн инновацын хаб нь хариуцан хэрэгжүүлэх хандлага түгээмэл байна.
- Хамтын ажиллагааны платформ. Технологийн дэвшлийн нөлөөгөөр санхүүгийн дэд салбар өөр хоорондоо, мөн санхүүгийн бус салбартай хослон хөгжиж байна. Түүнчлэн санхүүгийн зах зээл хил хязгааргүй хөгжин олон улсын зохицуулагч байгууллагуудын хамтын ажиллагааг улам их шаардах болсон. Технологийн хөгжил нь үргэлж зохицуулалтын үйл ажиллагаанаас урдявдаг учраас шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирсон зохицуулалтын орчныг бүрдүүлэхэд технологи хөгжүүлэгч, санхүүгийн компаниуд болон бодлого гаргагчдын хамтын ажиллагаа зайлшгүй шаардагдаж байна. Харин инновацын хаб нь санхүү, технологийн компаниуд, зохицуулагч байгууллагууд, эрдэмтэн судлаачид, хөрөнгө оруулагчдыг холбосон хамтын ажиллагааны платформын үүргийг гүйцэтгэдэг.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2021 оноос эхлэн сэндбоксын орчныг хөгжүүлж эхэлсэн бөгөөд 2022 оноос эхлэн сэндбоксын албыг байгуулан сэндбоксод оролцох хүсэлтийг хугацаа харгалзалгүй хүлээн авч эхэлсэн. Өнгөрсөн 1 жил гаруйн хугацаанд сэндбоксын албанд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ турших нийт 15 хүсэлт ирсэн. Үүнээс гадна өөрсдийн хөгжүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой бодлого, зохицуулалтын орчны талаас зөвлөгөө, мэдээлэл авахаар хандах тохиолдол их байгаа бөгөөд сэндбоксын алба нь 2022 оноос хойш нийт 18 компанитай 47 удаагийн уулзалтыг зохион байгуулсан байна. Энэ нь зах зээл дээр сэндбокс зохицуулалтаас гадна бусад төрлийн дэмжлэг, үйлчилгээний эрэлт өндөр буйг харуулж байна.

4.2. ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛ

Финтек инновацын хаб нь санхүүгийн технологийн хөгжлийг дэмжихийн сацуу комплаенсыг нь хангуулж, зохицуулалтын орчныг нь давхар хөгжүүлж байдгаараа гол давуу талыг үүсгэдэг. Финтек инновацын хабын давуу болон сул талыг дор харууллаа.

Давуу тал:

- Инновацыг дэмжинэ: инновацын хаб, сэндбокс зохицуулалт нь санхүү, технологийн компаниудад хууль, эрх зүйн орчны эрсдэлээс айлгүйгээр бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хөгжүүлэх боломжийг олгодог;
- Зохицуулалтын орчны тодорхой бус байдлыг бууруулна;
- Шинэ төрлийн үйлчилгээг зах зээлд амжилттай нэвтрүүлэх үйл явцыг хурдасгана;
- Хамтын ажиллагааг бэхжүүлэн, илүү үр ашигтай зах зээлийг үүсгэнэ;
- Хэрэглэгчид, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаална: инновацын хабын оролцогчид нь тодорхой шаардлага, стандартыг дагаж мөрддөг учир шинэ тутам үүсэж буй эрсдэлээс хэрэглэгчийг хамгаална;
- Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, хөрөнгө оруулалтыг татна.

Сул тал:

- Инновацын хабыг ажиллуулах нь хүний нөөц их шаарддаг бөгөөд чадварлаг мэргэжилтнүүдийг татаж ажиллуулах нь хүний нөөцийн зардлыг өсгөдөг;
- Инновацын хаб нь олон төрлийн оролцогчдын хамтын ажиллагааны талбар болдог учраас тэдгээрийн харилцааг зохицуулахад ихээхэн хүчин чармайлт шаарддаг;
- Өгөгдлийн нууцлал, аюулгүй байдлыг хамгаалах нь инновацын хаб болон оролцогч бүхий л талуудын хувьд хамгийн томоохон сорилт болж буй;
- Уламжлалт санхүүгийн байгууллагууд болон финтекийн компаниуд хоорондын ашиг сонирхлыг тэнцүүлэх сорилт тулгардаг;
- Инновацын хабыг амжилттай ажиллуулахад олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагаа ихээхэн шаардагддаг.

4.3. ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ

Зохицуулалтын орчны болон комплаенсын эрсдэл

- Эрсдэл: зохицуулалтын орчинд гарч буй өөрчлөлт, шаардлагууд нь инновацын хабын үйл ажиллагаанд нөлөөлөх боломжтой;
- Хариу арга хэмжээ: зохицуулагч байгууллагууд, төрийн бодлого гаргах байгууллагуудтай нягт хамтын ажиллагааг тогтоох, зохицуулалтын орчинд тохиож буй өөрчлөлт, хувьслын талаар тогтмол мэдээлэлтэй байж хариу арга хэмжээг тухай бүр аван, үйл ажиллагаагаа нийцүүлэх.

Санхүүжилтийн эрсдэл

- Эрсдэл: санхүүжилт тасалдсанаар хабын үйл ажиллагааг явуулахад хүндрэл үүсэх
- Хариу арга хэмжээ: засгийн газрын дэмжлэг, олон улсын байгууллагуудын тусламж, болон хөрөнгө оруулагчдаас санхүүжилт татах тасралтгүй механизмыг бүрдүүлэн, санхүүгийн төлөвлөлтийг сайтар гаргах;

Технологи болон аюулгүй байдлын эрсдэл

- Эрсдэл: өгөгдлийн аюулгүй байдал, кибер аюулгүй байдал болон технологийн тасралтгүй үйл ажиллагаанд эрсдэл үүсэх;
- Хариу арга хэмжээ: мэдээллийн аюулгүй байдал, кибер аюулгүй байдлыг хамгаалах бодлого, заавар, стандартыг мөрдөж, холбогдох аудитыг тогтмол хийлгэх;

Нэр хүндийн эрсдэл

